

аймгийн Лүн сумын Монгол-Хятадын найрамдлын нэрэмжит «Энхтуул» нэгдэл БНХАУ-ыг тунхагласны 38 жилийн ойгоор үдэшлэг уулзалт хийж тэмдэглэсэн бөгөөд БНХАУ-аас тус улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ли Жүйчин, бусад дипломатууд өргөн оролцов.

Манай нийгэмлэгийн үйл ажиллагаанд БНХАУ-ын ЭСЯ-аас идэвхтэй дэмжлэг үзүүлж байгаад МХНН-ийн нийт гишүүд баяртай байдаг юм.

Хоёр орны харилцааг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлж байгаа МЭТНБХ-ны гүйцэтгэх хороо, МХНН болон Бүх Хятадын гадаадтай найрамдах ардын нийгэмлэг, ХМНН цаашид харилцаагаа хөгжүүлэх асуудлыг тус тусдаа боловсруулж байна.

МЭТНБХ-ны гүйцэтгэх хороо, МХНН нь 1989 онд ХМНН-ийн идэвхтний төлөөлөгчдийг хүлээн авах, МХНН-ийн идэвхтэн гишүүдийн эгнээг өргөтгөх, БНХАУ-ын ололт амжилтыг Монголын олон нийтийн дунд өргөн сурталчлах, өөрийн ард түмний амьдрал, бүтээн байгуулалтыг БНХАУ-д сурталчлах зэрэг ажлыг явуулахаар төлөвлөж байна.

Монгол-Хятадын ард түмний найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд МХНН улам их нэмэр хандив оруулахын төлөө чармайн ажиллах болно.

МОНГОЛ-ЯПОНЫ ХАРИЛЦАА ҮҮСЭЖ ТОГТСОН НЬ

О. ОЮУНГЭРЭЛ

1921 оноос хойш МАХН, Монголын засгийн газар дэлхийн бүх ард түмэнтэй энх тайвнаар амьдрах гэсэн монголын ард түмний хүсэл эрмэлзлийг илэрхийлэн, нийгмийн өөр өөр байгуулалтай улсууд энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр капиталист орнуудтай харилцаа тогтоох саналаа дэвшүүлэн тавьж байлаа. Гэвч хөрөнгөтөн орнууд, Монголын ардын засгийг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоохоос эрс татгалзаж байв.

Дайны дараах жилүүдэд хүчний харьцаа социализмд ашигтайгаар өөрчлөгдөхөд БНМАУ олон улсын тавцан дээр гарч ирэх боломжтой болов. Ялангуяа социалист хамтын нөхөрлөлийн гишүүний хувьд БНМАУ ын олон улсын хэлхээ холбоо өргөжихийн зэрэгцээ зарим хөгжиж байгаа ба хөрөнгөтөн орнуудтай харилцаа тогтоох болжээ.

Дипломат хэлхээ холбоогоо өргөжүүлэх гэсэн манай улсын чиг шугам Ази тив дэх олон улсын байдалд чухал ач холбогдолтой байв. Үүнтэй уялдуулан БНМАУ-ын засгийн газар Япон улстай албан ёсны дипломат харилцаа тогтоох чармайлт гаргах болсон юм. Хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох явцад нэлээд бэрхшээл гарсан нь юуны өмнө Японы эрх баригчид АНУ-ын хомрогонд орж, БНМАУ-тай хоёр талын хэлхээ холбоо тогтоохоос янз бүрээр татгалзсантай холбогдож байв. Тухайлбал, Японы засгийн газар гоминданыхан Монголын газар нутаг руу өнгөл-

зөж байсныг зөвтгөн, манай улстай харилцаагаа хэвийн болгоход зохиомол саад бэрхшээл бий болгож байв.

1957 онд БНМАУ, Японтой харилцаагаа хэвийн болгох, хоёр орны хооронд хэдийгээр хурцдаагүй ч олон жил үргэлжилсэн дайны байдлыг зогсоох талаар саналаа илэрхийлсэн юм. ЗХУ, БНМАУ-ын засгийн газрын хоорондын хэлэлцээний тухай Зөвлөлт-Монголын хамтарсан мэдээнд, «БНМАУ-ын засгийн газар ЗХУ, Япон улсын хооронд дипломат харилцааг сэргээн тогтоосонтой холбогдуулан баяр хүргэж, хоёр орны хоорондын харилцааг хэвийн болгох асуудлаар японы засгийн газартай хэлэлцээ хийхэд бэлэн байгаагаа илэрхийлж байна»¹ гэж тэмдэглэсэн билээ.

Гэвч тэр үед японы эрх баригч намынхан Монголын засгийн газрын дээрх мэдэгдлийг хайхарч үзээгүй юм. Харин японы зарим алсын хараатай улс төрийн зүтгэлтэн хоёр улсын харилцааны хэвийн бус байдлыг ойлгож, БНМАУ-тай харилцааг хэвийн болгох сонирхолтой байлаа. 50-иад оны II хагасаас японы худалдааны төлөөлөгчид БНМАУ-тай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох боломжийг судлах алхамд шилжсэн юм. Энэ үед манай улс ч Японтой худалдаа, эдийн засгийн харилцааг эрх тэгш, харилцан ашигтай үндсэн дээр хөгжүүлэн өргөжүүлэх зарчмыг баримталж байв.

Ийнхүү 1957 оны 10 дугаар сарын 31-нд Бээжинд БНМАУ ба Японы худалдааны байгууллагын төлөөлөгчид хэлэлцээ хийсний дүнд ойрын хугацаанд худалдааны хэлхээ холбоо тогтоож, харилцан таваар нийлүүлэх тухай тохиролцжээ². 1960 оноос эхлэн БНМАУ-ын гадаад худалдааны нэгдэл, японы худалдааны хэд хэдэн пүүс харилцан бараа солилцох болов.

Худалдааны харилцаа сайжирсны зэрэгцээ 50-аад оны II хагасаас Японд монгол, Японы ард түмний хооронд найрсаг харилцаа тогтоох хөдөлгөөн өрнөж эхлэв. Монголд айлчилсан япончууд нутаг буцмагц сонин хэвлэлд Монголын ард түмний ололт амжилт, аж амьдралын тухай зөв бодитойгоор бичиж, хоёр орны хооронд улс төр, ажил хэргийн хэвийн харилцаа тогтоох гэсэн хүсэл эрмэлзлэлтэй байв. Үүний үр дүнд 1958 онд Токиод, «Япон-Монголын нийгэмлэг» байгуулагдав. Бодит байдлыг харгалзан, олон нийтийн саналын дагуу Японы эрх баригчид БНМАУ-тай харилцаа тогтоох алхмыг ийм замаар хийж эхлэв. Эхний үед Японы засгийн газар Варшав дахь элчин сайдын яамаар дамжуулан Монголын төлөөлөгчидтэй албан бус хэлхээ холбоо тогтоов.

1961 оны 10 дугаар сард БНМАУ НҮБ-ын гишүүнд элсэж, манай улсын талаар явуулж байсан империалист гүрнүүдийн ялгаварлан гадуурхах бодлогод цохилт өгсөн нь Монголын олон улсын нэр хүнд өсөхөд тус дөхөм болж, түүний гадаад улс төрийн хэлхээ холбоог цаашид хөгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэв.

1960-аад оны үеэр БНМАУ, Японы хооронд худалдаа, олон нийтийн байгууллагуудын төлөөлөгчид харилцан айлчилсаар байв. Монголын төлөөлөгчид Японд болсон цөмийн болон ус төрөгчийн зэвсгийг хориглох олон улсын бага хурал, симпозиумд оролцож, Монголын ЭТНБГХ-ын шугамаар манай улсад «Япон—Монголын нийгэмлэг» болон японы үйлдвэрчний эвлэлийн (СОХИО) төлөөлөгчид тус тус айлчилж байв.

1969 онд Монголын ардын хувьсгалын 48 жилийн ойд оролцохоор манай улсад японы парламентын төлөөлөгчид анх албан ёсны бус хэмжээнд айлчилж, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга, ГЯЯ-ны сайд

зэрэг албаны хүмүүстэй уулзаж хоёр орны харилцааг хэвийн болгох тухай хэлэлцээ хийв³. 1970 оны 7 дугаар сард Монголын худалдааны танхимын урилгаар хоёр талын худалдаа, эдийн засгийн харилцааг цаашид хөгжүүлэх тухай асуудлаар «ЗХУ болон европын социалист орнуудтай худалдаа хийх японы Ассоциацийн» ерөнхийлөгч Т. Кацураги манай оронд хүрэлцэн иржээ. Монгол-Япон улсын хооронд соёл урлаг, шинжлэх ухааны салбарын зүтгэлтнүүдийн харилцан айлчлалт үргэлжилсээр байв.

Японы олон нийт БНМАУ-тай хэвийн харилцаа тогтоохыг шаардан албаны дээд байгууллагуудад шийдэмгий шахалт үзүүлж байсныг эдгээр баримт гэрчилнэ. Хэрэв 50-60-аад онд олон нийт, худалдааны байгууллагын шугамаар явагдаж ирсэн хэлхээ холбооны явцад хоёр тал бие биеийнхээ байр суурийг харилцан судлах оролдлого хийж байсан бол, 1970 оны эхээр монгол, Японы хооронд парламентын төлөөлөгчдийн хэмжээнд харилцан айлчлал өргөжиж эхэлсэн билээ.

1970 оны 8 дугаар сард Монголын тал Японы засгийн газраас олон улсын ЭКСПО-79 үзэсгэлэнг үзэн сонирхох урилгыг хүлээн авсан юм. Монголын төлөөлөгчид Японд байхдаа дипломат харилцаа тогтоох, хоёр орны хооронд эдийн засаг, соёлын солилцоог цаашид хөгжүүлэх зэрэг асуудлаар саналаа солилцжээ.

1971 оны 9 дүгээр сард БНМАУ-ын засгийн газрын урилгаар японы либерал-ардчилсан намын парламентын группийн дарга С. Накажима тэргүүтэй японы сайн санааны төлөөлөгчид Монголд айлчилжээ. Эдгээр хэлхээ холбоогоор хоёр орны харилцааг хэвийн болгох хэлэлцээг үр дүнд хүргэх эх суурь тавигдаж байв.

БНМАУ-ын засгийн газар Японтой албаны бус шугамаар хэлхээ холбоо тогтоон харилцахдаа, нийгмийн өөр өөр байгуулалтай улс орон энх тайвнаар зэрэгцэн орших ленинч зарчмыг баримтлан, Азийн томоохон гүрэн болох Япон улстай албан ёсны хэмжээнд харилцааг хэвийн болгох тухай хүсэл эрмэлзэл, бүх салбарт эрх тэгш, харилцан ашигтай үндсэн дээр харилцааг хөгжүүлэхэд бэлэн байгаагаа нэг биш удаа илэрхийлж байлаа. Японы тал ч 1961, 1965, 1966, 1968 онуудад тус бүр ГЯЯ-ны 2 ажилтны бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг БНМАУ-д илгээн хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар санал солилцож байв. Ийнхүү урьдчилсан хэлэлцээний явцад монголын тал 1939 он болон дэлхийн II дайны жилүүдэд японы дайнчдаас БНМАУ-д учруулсан хохирлыг нөхөн төлөх асуудлыг зүй ёсоор хөндөж тавьсан юм. Үүний сацуу монголын засгийн газар дайны төлбөрийг хоёр орны харилцааг хэвийн болгох тухай асуудалтай холбохгүй жичид нь авч хэлэлцэх асуудал болгон үзэж байв⁴.

БНМАУ, Япон улсын хооронд албан ёсны харилцаа тогтоох гол саад гэж японы эрх баригч нарын үзэж байсан гол асуудлын нэг нь ийнхүү манай улсын зарчимч байр суурь хандлагын ачаар зөв зохистойгоор шийдвэрлэгдсэн юм. Энэ үед Монгол улсын социалист бүтээн байгуулалтдаа улам их амжилт олж, олон улсын нэр хүнд нь ихэд нэмэгдэж, зөвхөн 1963-1970 оны хооронд манай орныг 10 орчим капиталист орон хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоожээ.

Ийм нөхцөлд Япон улс, социалист орнууд, түүний дотор БНМАУ-тай харилцааг хэвийн болгох явдалд тухайн цаг үеийн байдлыг харгалзахгүй байж чадаагүй билээ 70-аад оны эхээр дэлхийн тавцан дээрх ерөнхий байдал өөрчлөгдөж, олон улсын хурцадмал байдал намжсаны үр дүнд

японы эрх баригчид «олон талт дипломат бодлогын» концепцийг дэвшүүлэн гаргажээ Энэ нь АНУ-ыг дангаар баримтлах бодлогоос хэсэгхэн холдож, дэлхийн бүх оронтой хэвийн харилцаа хөгжүүлэх гэсэн бодлого байлаа

Японы засгийн газрын ийнхүү «бие даасан» алхам хийх болсон нь АНУ өөрийн дотно холбоотон Японы саналыг үл харгалзан Хятадтай 70-аад оны эхээр шууд хэлхээ холбоо тогтоосонтой холбоотой гэж зарим улс төрийн бодлоготнууд тайлбарладаг юм. Үнэн хэрэг дээрээ Японы засгийн газар гадаад улс төрийн бодлогодоо социалист орнуудын улс төр, эдийн засаг, цэргийн хүчин чадал нэмэгдсэнийг харгалзахаас өөр аргагүй байжээ. Тэд нөгөө талаар монгол-японы хэлхээ холбоог Японы олон улсын байр суурийг бэхжүүлж, өөрийн орны эдийн засгийн салбарт ашиглах сонирхолтой байлаа. Энэ бүхэн нь БНМАУ, Японы харилцааг хэвийн болгоход урьдчилсан нөхцөлийг бүрэлдүүлж байв. Японтой харилцааг түргэн хугацаанд хэвийн болгоход чиглэсэн БНМАУ-ын тууштай зарчимч чиг шугам үүнд багагүй үүрэг гүйцэтгэв.

1972 оны 2 дугаар сарын 24-нд БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоов. Энэ нь хоёр орны цаашдын олон талын хэлхээ холбоог хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой үйл явдал болсон төдийгүй Ази, Алс Дорнодын улс төрийн уур амьсгалыг эрүүлжүүлэх үйл хэрэгт зохих хувь нэмэр болсон юм.

БНМАУ-ыг АНУ хүлээн зөвшөөрөхөөс эрс татгалзаж байсан тухай нөхцөлд Японы засгийн газар БНМАУ-тай найрсаг харилцаа тогтоосон явдал нь Японоос социалист орнуудтай хэвийн хэлхээ холбоо тогтоох биеэ даасан хандлага гарч ирснийг нотлон харуулав.

Дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр улс засгийн газар болон ажил хэргийн шугамаар төлөөлөгчдийг харилцан солилцож, хоёр талын харилцааны асуудал, мөн Ази тивд түгшүүртэй байдлыг намжаах нөхцөл бүрдүүлэх явцад хамарсан олон улсын асуудлыг хэлэлцэх болов. 1977 оны 3-р сарын 17-нд «БНМАУ, Япон улсын хооронд эдийн засгийн талаар хамтран ажиллах тухай хэлэлцээрт гарын үсэг зуржээ.

Монгол-Японы харилцаанд соёл, шинжлэх ухааны салбар дахь хамтын ажиллагаа чухал байр эзэлж байна. 1950-иад оны дунд үеэс эхэлсэн монгол-япон улсын хоорондох соёлын хэлхээ холбоо нь харилцаа хэвийн болгох үйл хэрэгт багагүй роль гүйцэтгэж ирсэн. Үүнд эрдэмтдийн хооронд явагдаж ирсэн эрдэм шинжилгээний хэлхээ холбоог чухалчлан хэлэх хэрэгтэй юм.

1957 онд монгол, японы эрдэмтдийн анхны уулзалт Токиод болсон атом, ус төрөгчийн бөмбөгийг хориглох олон улсын бага хуралд манай нэрт эрдэмтэн Ц. Дамдинсүрэн, Ш. Лувсанвандан тэргүүтэй төлөөлөгчид оролцох үед болжээ. Дараа нь Улаанбаатарт зохион явагддаг олон улсын монголч эрдэмтдийн их хуралд японы эрдэмтэд 1959 оноос хойш тогтмол оролцох болов. Ийм харилцаа нь хоёр орны ард түмний бодит байдлыг харилцан танин мэдэхэд тус дөхөм болж байв.

1974 оны 9 дүгээр сарын 23-нд Монгол, Японы засгийн газрын хоорондын соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулах явдалд Японы талаас японы монголч эрдэмтдийн нийгэмлэг зохих хувь нэмэр оруулав. Уг хэлэлцээрийн дагуу хоёр улс эрдэмтэд, багш, оюутан, жүжигчид, биеийн тамирчдыг тогтмол солилцож, янз бүрийн арга хэмжээ зохион явуулж байна. 1974 оноос эхлэн соёлын хэлэлцээний шугамаар хоёр орны эрдэмтэд «эрдэм шинжилгээний практик судалгааг» хамтран явуулах боломжтой болов. 1975 оноос монголыг суд-

лаач японы эрдэмтэд монгол судлалын чиглэлээр идэвхтэй ажиллах болсон юм. Тэдгээрийн судалгаа түүх, хэл зохиол, хөдөө аж ахуйн хөгжлийн асуудлыг судлах гурван үндсэн чиглэлээр явагдаж ирсэн.

Сүүлийн үед японы эрдэмтэд БНМАУ дахь хөдөө аж ахуй-газар тариалан, мал аж ахуйн орчин үеийн хөгжлийн асуудалд их анхаарал хандуулж байна. Японд монголын судлал хөгжиж эхэлсэн үеэс монголын нийгмийн түүхийг судлах уламжлалт зүйлийн нэг бол Монгол орны нүүдлийн аж амьдрал, мал аж ахуйн хөгжлийн судалгаа байлаа. Энэ сэдвээр японы эрдэмтэд олон зуун зохиол, бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэний дотор хувьсгалаас хойш монголын ард түмний уламжлалт аж амьдралд гарсан бөгөөд гарч байгаа үндсэн өөрчлөлтүүдийн талаар тэдний хийсэн судалгаа нэлээд сонирхол татаж болох юм. Манай эрдэмтэд японы эрдэмтэдтэй нийгмийн болон байгалийн ухааны тодорхой чиглэлээр хамтран ажиллахаас гадна, манай япон хэлний мэргэжлийн хүмүүс, судлаач нар Японд монголын эрт эдүүгэйн хөдөө аж ахуйн хөгжлийн талаар хийсэн судалгааг нарийвчлан судалж, үнэлэлт, дүгнэлт хийгүүштэй санагдана.

БНМАУ, Япон улсын хоорондын харилцаа нь Алс Дорнодод намжмал байдлыг тогтоох үйл ажиллагаанд чухал байр эзэлж байгаа юм. Хоёр улс нь хэлхээ холбоо өргөжүүлж байгаа явдал нь Азид энх тайван, олон талын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд нааштайгаар нөлөөлөх нь дамжиггүй билээ.

1987 оны 5 дугаар сард БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 15 жилийн ойгоор БНМАУ-ын Гадаад явдлын яамны сайд Японд хийсэн албан ёсны анхны айлчлалын үеэр хоёр орны харилцааг тогтвортой үндсэн дээр цаашид хөгжүүлэх эрмэлзэлтэй байгаагаа хоёр тал илэрхийлсэн билээ.

Монгол-японы харилцааны цаашдын хөгжил нь Японы эрх баригч бүлгийнхэн Ази, Номхон далайн бүс нутаг дахь олон улс-улс төрийн байдлын хөгжлийн төлөвийг хэрхэн зөв үнэлэх, монгол-японы ард түмний эрх ашиг, хүсэл эрмэлзлэлийн дагуу сайн хөршийн харилцааг бэхжүүлэх талаар зүй зохистой алхам аль зэрэг хийхээс ихэд хамаарах болно.

1. «Правда» 1957. V. 17
2. «Үнэн» 1957. XI. 4
3. «Вага гайко-но кинкё». Токио, 1970, No 14 (II), x. 90
4. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгийн эмхтгэл 3-р боть. УБ. 1972. x: 423